



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 12. 20 № 55-134-12/8169
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240103771 дугаартай "Үйлдвэрийн дүүрэгт ажилладаг ажилтнуудад халуун хоолоор үйлчилгээ үзүүлэх ажил-I" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг сонирхогчоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1... хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА



П.БАТБОЛОР

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407033444

Тодруулга №1:

Даалгавар 3.1-д төлөвлөгөөт цэсийг 4 улирлаар тооцоолон гаргах....

Хоолны төлөвлөгөөт цэсийг тооцохдоо улирлын чанарт тулгуурлан /зун, намар, өвөл, хавар /хүнсний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, хүний биеийн онцлогт тохируулан /хий, шар, бадган зэрэг/ тооцож 1 сарын цэс буюу 4 долоо хоногоор тооцож гаргах. Нийт 4 улирлаар буюу 16 долоо хоногийн цэс гарна.

Тодруулга 2:

Даалгавар 3.3:

Хээрийн хоолны үйлчилгээг үзүүлэхдээ нийт 4-12 сар буюу нийт 8 сард ажиллах нөхцөлтэйгөөр 3 улирлаар тооцно. 1 сарыг 4 хоногоор тооцсон төлөвлөгөөт цэсийг гаргана.

Тодруулга 3:

Даалгавар 3.5:

Төлөвлөгөөт цэст жимс, жимсгэнийг хоногт өдөр, орой, шөнийн ээлжийн турш олгоно.

Тодруулга 4:

Даалгавар 6.2.2:

Тендерт оролцогч нь хоногт 2200 ажилтанд халуун хоол үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлэх учраас бид цаашид мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрсдэлийн тооцох үүднээс орон нутаг болон улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага сонгохыг зорин ажиллаж байна. Иймд үйлдвэрийн аргаар мах, махан бүтээгдэхүүнийг ангилан бэлтгэдэг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээг хавсаргаж ирүүлэхийг шаардсан.

Тодруулга 5:

Даалгавар 6.2.4:

Гурван сайдын баталсан хавсралтад дурдсан ариутгал, халдваргүйтгэл, угаалга цэвэрлэгээний бодисуудыг нийлүүлдэг аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ ирүүлнэ.

Тодруулга 6:

Тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж баталдаг. Иймд тус V бүлэг дэх 12 төрлийн маягтыг батлагдсан загварын дагуу бэлтгэж тендерт оролцоно.